

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫГ 2021 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ НЭГДСЭН БОДЛОГО”-ЫН АГУУЛГА

Нэг. Хөдөө аж ахуйн хөгжлийн өнөөгийн байдал,

Хоёр. Нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үе шат

Гурав. Бодлогын хэрэгжилтийн зохион байгуулалт, зарчим

- 3.1. Бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт
- 3.2. Нэгдсэн бодлогыг аймгийн дэд хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх нь
- 3.3. Хөдөө аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх бодлого болон сумдын хөдөө аж ахуйн салбарын тэргүүлэх чиглэлүүд

Дөрөв. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэтийн зорилго, тэргүүлэх зорилтууд

- 4.1. Салбарын хэтийн зорилго
- 4.2. Салбарын зорилго, тэргүүлэх зорилтууд

Тав. Газар тариалангийн салбарын хөгжил, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

- 5.1. Газар тариалангийн салбарын хөгжил
- 5.2. Газар тариалангийн салбарын зорилго, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

Зургаа. Мал аж ахуйн салбарын хөгжил, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

- 6.1. Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал.
- 6.2. Мал аж ахуйн салбарын зорилго, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

Долоо. Хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн үйлчилгээний өнөөгийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн.

- 7.1. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний өнөөгийн байдал
- 7.2. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний зорилго, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

Найм. Хөдөө аж ахуйн салбарын чадавхийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

- 8.1. Бэлчээрийн менежментийн өнөөгийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн
- 8.2. Малын тэжээлийн хангамжийн өнөөгийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

8.3. Хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөц, сургалт, нэвтрүүлэлтийн үйлчилгээний өнөөгийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2009 оны 36 дугаар тогтоолоор батлав

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫГ 2021 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ НЭГДСЭН БОДЛОГО

Нэг. Аймгийн хөдөө аж ахуйн хөгжлийн өнөөгийн байдал, үйлдвэрлэлд нөлөөлж буй хүчин зүйлс

1.1. Өнөөгийн байдал

Дархан-Уул аймаг нь Хан Хэнтий, Хангайн нурууны хооронд Орхон, Сэлэнгийн сав газрын бүсэд багтдаг ба ой, хээр, уулс хосолсон байгаль, экологийн өвөрмөц тогтолцоотой юм.

Нийт газар нутгийн 70.7 хувь буюу 231.7 мянган га талбай нь ХАА-н эдэлбэр газар бөгөөд үүний 81.5 хувь буюу 188.5 мянган га нь бэлчээр, 3.9 хувь буюу 9.1 мянган га талбай нь хадлан, 13.9 хувь буюу 33.4 мянган га нь тариалангийн зориулалттай эргэлтийн талбай эзэлж байна.

Дархан-Уул аймаг нь Монгол улсын газар тариалангийн төв бүсэд оршдог. 2007 оны байдлаар аймгийн дотоодын нийт бүтээгдхүүнд хөдөө аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэл 19.3 хувийг эзэлж байна.

Аймгийн хөдөө аж ахуйн нийт бүтээгдхүүнд газар тариалангийн бүтээгдхүүний үйлдвэрлэл голлодог бөгөөд газар тариалангийн аж ахуйнууд шинжлэх ухааны баазтайгаа ойрхон байрлаж, түүнтэй хамтран ажилладгаараа бусад аймгуудаас давуутай юм.

Монголын атрын анхны шан тавьсан 4 аж ахуйн нэг Дархан сангийн аж ахуй байсан бөгөөд газар тариалангийн ид хөгжил цэцэглэлтийн үе 1980-аад онд манай аймаг жилдээ 16.0-21.1 мянган га-д үр тариа, 350-1000 га-д төмс, хүнсний ногоо тариалж, 15.5-32.1 мянган тонн үр тариа, 7.1-12.7 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан авч, өөрийн аймгийн хэрэгцээг бүрэн хангадаг стратегийн ач холбогдол бүхий салбар болтол хөгжүүлж чадсан.

Тус аймгийн Дархан сангийн аж ахуй нь буудайн элит үр үйлдвэрлэдэг, Орхон сангийн аж ахуй нь төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, дахин боловсруулах чиглэлээр, Ургамал газар тариалан, сургалт эрдэм шинжилгээний Хүрээлэн үр тариа, төмс, хүнсний ногооны шинэ сорт гаргах, нутагшуулах, төмс, хүнсний ногооны үр үйлдвэрлэлээр улсдаа тэргүүлэх байр суурийг эзэлсэн, одоо ч энэ шинж чанараа хадгалсан хэвээр байна.

Аймгийн хэмжээгээр сүүлийн жилүүдэд 12787.5-2206 га-д үр тариа тариалж, 1647.2-13068.5 тн ургац, 292.2-654.8 га-д төмс тариалж, 2500.8-5097.8 тн ургац, 222.7-765.3 га-д хүнсний ногоо тариалж, 1952.7-8338.8 тн ургац хураан авсан нь иргэдийн хэрэгцээт төмс, хүнсний ногоог бүрэн, үр тарианы хэрэгцээний 15-70 хувийг хангах хэмжээний үйлдвэрлэл явуулж байна.

Анх 1965 онд Дархан хот байгуулагдахад 4.3 мянган толгой малтай байсан тус аймгийн малын тоо, толгой тогтвортой өсөж, одоогоор 2.0 мянган гаруй өрхөд 230.0 гаруй мянган толгой малыг өсгөн үржүүлэх болж, мал аж ахуйн үйлдвэрлэлээс жилд дунджаар 1.5-2.0 тонн малын мах, 6.5-9.5 сая литр сүү, 80-82 тонн ноос, 7.0-7.5 тонн

ноолуур, 7.2-7.3 тонн хөөвөр, 20.0-22.0 мянган ширхэг арьс ширийг үйлдвэрлэж, хүн амын хүнсний хэрэгцээт махны 20.0, сүү, сүүн бүтээгдхүүний 60.0, өндөгний 10.0 орчим хувийг тус тус хангаж байна.

Төв суурин газрыг чиглэсэн хүн, малын их нүүдлийн дунд бий болж буй малын механик өсөлтөөс болж бэлчээрийн даац хэтэрсэн, хүн амын хүнсний хэрэгцээ ихтэй аймгийн бодит нөхцөлд мал аж ахуйг эрчимжүүлэх, таваарлаг чанар сайтай өндөр ашиг шимт, сайжруулагч малыг өсгөх нь аймгийн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогын үндсэн чиглэл юм. Одоогийн байдлаар аймагт 21 үүлдэр, омгийн 47.8 мянган толгой малыг үржлийн сайжруулагчаар ашиглаж байгаа нь нийт малын 20.7 орчим хувийг эзэлж байна.

Газар тариалангийн төв бүсэд оршдог, хадлан тэжээлийн ургац арвинтай тус аймгийн хувьд мал аж ахуйг эрчимжүүлэх үндсэн нөхцөл болсон тэжээлийн бааз суурийг бүрдүүлэхэд олон давуу талуудтай бөгөөд жилдээ 20.0-25.0 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх тэжээл үүний дотор 40.0-55.0 мянган тонн байгалийн хадлан бэлтгэснээр нэг хонин толгойд 45-56 кг тэжээлийн нэгж тэжээл ноогдож байна.

Монгол улсын нийгэм, эдийн засгийн хүрээнд томоохон байр суурийг эзлэх, бүс нутгийн хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэх учиртай төвийн бүсийн тулгуур төв Дархан-Уул аймгийн хувьд “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д төвийн бүсийн хөдөө аж ахуйн хөгжлийн тэргүүлэх чиглэл болох газар тариалан, мал аж ахуй хосолсон эрчимжсэн аж ахуйдыг хөгжүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн үйлдвэрлэлээр улсыг хангах түвшинг нэмэгдүүлэх зорилтыг аймгийн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогын гол чиглэл болгон хэрэгжүүлэн ажиллах шаардлага байгаа юм.

1.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлж буй цаг уурын хүчин зүйл, цаашдын төлөв, хандлага

Дэлхийн цаг уурын байгууллагын Уур амьсгалын судалгааны төвүүдийн нэг болох Хэйдлийн төвөөс Монгол орны уур амьсгалын ирээдүйн өөрчлөлтийг 2020 он хүртэл жилийн 4 улирлаар 1961-1990 оны дундаж уур амьсгалтай харьцуулж тооцоолсон судалгаанаас үзэхэд манай оронд өвөлдөө цас ихтэй, дулаан болох, харин зундаа халуун, хуурайших хандлага давамгайлж байна.

Агаарын температурын эрчимтэй дулааралт төвийн бүсийн нутгуудад ажиглагдах, жилийн нийлбэр ууршиц температурын өсөлтөөс шалтгаалж хур тунадас 2 түүнээс олон дахин нэмэгдэх хандлагатай байна. Цаг уурын байгууллагын хийсэн дүгнэлт, урьдчилсан таамаглалаар төвийн бүс 2075 он хүртлэх хугацаанд зундаа хуурай, халуун, өвөлдөө цас ихтэй, дулаавтар, цөлийн бүс Улаанбаатараас хойшоо өнгөрөх магадлалтай байна.

Уур амьсгалын дэлхий нийтийн дулааралт нь цаг уурын улирлын зарим онцлогийг хувиргаж, ургалтын хугацааны хөрс, агаарын ашигтай температурыг уртасгаж, хөлдөлтийн гүнийг бууруулж байгаа төдийгүй хүн, малын зарим өвчин эмгэг нэмэгдэх, хөрс орчинд нян бактери, хортон шавьж амьдрах хоног хугацаа нэмэгдэх нөхцөл бүрдэх юм.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлж буй бас нэг гол хүчин зүйл бол усны нөөцийн асуудал юм. Улсын хэмжээгээр усны нөөц багасаж байгаагийн дотор ширгэсэн гол, горхи, нуур, цөөрмийн дийлэнх нь Төвийн бүсэд байна. Дархан-Уул аймагт алт олборлох, хүний хүчин зүйлээс шалтгаалж буй экологийн сөрөг нөлөөлөл зэргээс үүдэн голуудын усны нөөц багасч, олон горхи, булаг ширгээд байна.

Хөрсний бүтцийн хувьд хөнгөн, элсэнцэр механик бүтэцтэй учир хүн мал, машин техникийн нөлөөгөөр элэгдэл, эвдрэлд хялбархан орж, цөлжих үйл явц эрчимжиж байна.

Дархан-Уул аймгийн Агро цаг уурын станц нь Монгол улсын хэмжээнд байдаг ганц ХАА-н цаг уурын станц бөгөөд таримал болон бэлчээрийн ургамлын үзэгдэл зүйн ажиглалт, хөрсний чийгийн болон ууршилтийн ажиглалтуудыг түлхүү хийдэг.

Цаашид хөдөө аж ахуйн цаг уурын судалгаа, шинжилгээний ажлыг үйлдвэрлэлтэй уялдуулан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулах үүднээс урьдчилан мэдээлэх салбарт технологийн шинэчлэл хийж, ажиглалт, туршилтын талбайтай болох замаар шинжилгээний ажлыг чанарыг шинэ түвшинд гаргах шаардлага байна.

Хоёр. Нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үе шат

Аймгийн “Хөдөө аж ахуйг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”-ыг хөгжлийн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хөгжлийн нэгдүгээр үе шат – 2008 -2012 он
2. Хөгжлийн хоёрдугаар үе шат – 2013 -2021 он

Гурав. Бодлогын хэрэгжилтийн зохион байгуулалт, зарчим

3.1. Бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Аймгийн “Хөдөө аж ахуйг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах удирдлага, зохион байгуулалт нь доорхи зарчимд суурилна. Үүнд:

1. Нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, бодлогын хүрээнд холбогдох дэд хөтөлбөр, төслүүдийг боловсруулан батлуулах, шаардагдах хөрөнгийг тооцон улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах үйл ажиллагааг аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс

2. Бодлого, дэд хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах үйл ажиллагааг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэхь аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, сумдын Засаг даргын Тамгын газар, мал эмнэлэг, үржлийн орон нутгийн үйлчилгээний нэгжүүд

3. Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагааг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, тэдгээрийн харьяанд ажиллаж буй сумдын хөдөө аж ахуйн хяналтын байцаагч нар

4. Нэгдсэн бодлогын хүрээнд хэрэгжиж буй аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий салбар зөвлөл, ажлын хэсгүүд тус тус хариуцна.

3.2. Нэгдсэн бодлогыг аймгийн дэд хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх нь

Хөдөө аж ахуйн салбарт Монгол Улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж буй Үндэсний хөтөлбөрүүдийн зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор болон аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогтой холбоотойгоор 1995 оноос хойш нийт 17 хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийг батлуулсанаас 10 хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дуусаж, одоогоор доорхи 7 хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж байна. Үүнд:

1. “Хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах” хөтөлбөр /1998-2010/
2. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр /2004-2015/
3. “Ногоон хувьсгал” 2 дахь шатны хөтөлбөр /2005-2012/
4. “Сүү” дэд хөтөлбөр /2007-2015/
5. “Жимс, жимсгэнэ” хөтөлбөр /2007-2012/
6. “Бруцеллёз” дэд хөтөлбөр /2007-2009/
7. “Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр /2008-2010/

“Аймгийн хөдөө аж ахуйг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”-ыг боловсруулахдаа одоо хэрэгжүүлж буй дээрхи хөтөлбөрүүдийн зорилго, зорилттой уялдуулсан бөгөөд энэхүү нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр нь эдгээр хөтөлбөрүүдийн санхүүжилт байх юм.

3.3. Хөдөө аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх бодлого болон сумдын хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүд

3.3.1. Хөдөө аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх бодлого

Дархан–Уул аймгийн 4 сум нь хоорондоо газар зүйн байрлал, экологийн орчин, ургамлан бүрхэвч, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалт, зориулалтын хувьд харилцан адилгүй байдаг. Аймгийн нийт хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 75.3 хувь нь Хонгор, 19.6 хувь нь Орхон, 4.2 хувь нь Шарын гол, 2.8 хувь нь Дархан суманд тус тус ашиглагдаж байна.

Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрхэлж ирсэн дадлага, туршлага, хүн хүчний нөөц, нэгэнт бий болсон үйлдвэрлэлийн бааз суурь бас харилцан адилгүй байна.

Хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэхэд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа байгалийн нөөц, чадавхи, газар, мал, техник, технологийн нөөцийг харгалзан аж ахуйдыг зөв хослуулан хөгжүүлэх зохистой хэмжээ, бүтцийг тогтоох шаардлагын үүднээс хөдөө аж ахуйн дэд салбаруудыг бүсчилэн хөгжүүлэхээр төлөвлөлөө. /Зураг 1-3-аар үзүүлэв/

Энэ үзэл баримтлал, чиг хандлагын дагуу сум, багийн түвшинд хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогыг тодорхойлон, газрын, бэлчээрийн менежментийн, бүтээгдхүүн үйлдвэрлэлтийн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх болно.

3.3.2. Сумдын хөдөө аж ахуйн салбарын тэргүүлэх чиглэлүүд

Энэхүү бодлогод хөдөө аж ахуйн дэд салбаруудыг аймгийн нутаг дэвсгэрт бүсчилэн хөгжүүлэхээр тусгасны зэрэгцээгээр сумдад тэргүүлэх чиглэлийг доорхи байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Хонгор суманд:

- Үр тарианы үйлдвэрлэл (үндсэн үйлдвэрлэл)
- Буудай, төмсний сортын үр үйлдвэрлэл
- Усалгаатай үр тарианы үйлдвэрлэл
- Сүүний болон махны чиглэлийн үхрийн аж ахуй

- Ноос-махны хонины аж ахуй /нарийн, нарийвтар ноост хонь/
- Гахайн аж ахуй
- Таримал тэжээлийн үйлдвэрлэл, байгалийн хадлан бэлтгэл

2. Орхон суманд :

- Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл /үндсэн үйлдвэрлэл/
- Төмс, хүнсний ногооны үр, жимс, жимсгэний суулгац үйлдвэрлэл
- Хамгаалагдсан хөрсний ногоо, жимсний аж ахуй /үндсэн үйлдвэрлэл/
- Зоорийн аж ахуй
- Сүүний үхэр, сүүний ямаа, махны чиглэлийн хонины аж ахуй
- Гахайн аж ахуй
- Зөгийн аж ахуй

3. Шарын гол суманд:

- Өрхийн тариалан /үндсэн үйлдвэрлэл/
- Мах-ноосны хонины аж ахуй /үндсэн үйлдвэрлэл/
- Сүү болон махны үхрийн аж ахуй
- Махны чиглэлийн хонины аж ахуй

4. Дархан суманд:

- Өрхийн тариалан /үндсэн үйлдвэрлэл/
- Зоорь, агуулахын аж ахуй
- Хот орчмын сүүний үхрийн аж ахуй
- Гахай, шувууны аж ахуй
- Тэжээлийн үйлдвэрлэл

Дөрөв. Дархан-Уул аймгийн хөдөө аж ахуйн салбарын хэтийн зорилго, бодлогын хөгжлийн үе шатны зорилго

4.1. Салбарын хэтийн зорилго: Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл, баримтлал, “Төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-д нийцүүлэн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, хөгжүүлэх цогц арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлсэнээр үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхийг дээшлүүлэхийн зэрэгцээгээр аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг экологийн, чанартай бүтээгдхүүнээр тасралтгүй ханган улмаар гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

4.2. Салбарын зорилго, тэргүүлэх зорилтууд

4.2.1. Хөгжлийн нэгдүгээр үе шатанд /2008-2012 он/: Газар ашиглалтыг эрс сайжруулан, тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлэн, мал аж ахуй, газар тариаланг зөв хослуулан эрчимжүүлэн, бүсчилэн хөгжүүлэх, бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах замаар хөдөө аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэнээр аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа, мах, сүү, өндөгний хангамжийг сайжруулан, төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангаж, улмаар зах, зээлд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

4.2.2. Хөгжлийн хоёрдугаар үе шатанд /2013-2021 он/: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухаанд суурилсан шинэ техник, технологи, биотехнологийн аргыг өргөнөөр нэвтрүүлэх, эрчимжилтийн явцыг түргэсгэх замаар аж ахуй эрхлэгчдийн чадавхийг дээшлүүлэн, нэг га-аас авах ургац, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлсэнээр аймгийн хүн амын мах, махан бүтээгдхүүн, өндөгний хэрэгцээг 60.0 орчим хувиар, бусад бүтээгдхүүний хэрэгцээг бүрэн хангахын

зэрэгцээгээр төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн төвийн бүсийн үйлдвэрлэлд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.

Тав. Газар тариалангийн салбарын хөгжил, зорилго, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

5.1. Газар тариалангийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал

Дархан-Сэлэнгийн бүс нутаг нь улсын хэмжээний үр тарианы 55.0-60.0, төмс, хүнсний ногооны 25.0-35.0 хувийг дангаараа үйлдвэрлэж, хүн амыг эх орны хөрсөнд ургуулсан, эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдхүүнээр хангахад томоохон үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд цаашид ч ач холбогдол нь улам өсөн нэмэгдэх болно.

Монгол улсын газар тариалангийн шинжлэх ухааны толгойлох байгууллага болох Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн нь орон нутагт байрлаж, үйл ажиллагаа явуулж байдгийн хувьд Монгол орны болон бүсийн газар тариалангийн салбарын өнөөгийн дүр төрх болон цаашдын чиглэлийг тодорхойлоход Дархан-Уул аймгийн газар тариалангийн салбарын хөгжил чухал нөлөөтэй байгаа билээ.

Тус аймаг газрын нэгдмэл сангийн балансад тусгагдсанаар нийт 33.4 мян.га тариалангийн эргэлтийн талбайтай, 2007 оны байдлаар 10.7 мян.га талбайд тариалж, 4.7 мян.га талбайг уринш, цэвдэгшээр боловсруулж, 18.0 мян.га талбайг ашиглаагүй байна.

2007 оны байдлаар үр тарианы чиглэлээр 17, төмсний 26, хүнсний ногооны 24 аж ахуйн нэгж, нийт 7360 өрх тариалангийн үйлдвэрлэл эрхлэж байна.

Дархан-Уул аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг улсын түвшинтэй харьцуулахад тариалан эрхлэгч аж ахуйн нэгжийн 3.1, өрхийн аж ахуй эрхлэгчдийн 5.7, нийт эргэлтийн талбайн 4.3, уриншийн 2.5, тариалангийн талбайн 5.7, ургацын хувьд үр тарианы 1.7, төмсний 5.0, хүнсний ногооны 12.0 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн тариаланчдын 2007 онд үйлдвэрлэсэн ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн нь хүн амын хэрэгцээт үр тарианы 19.0, гурил, гурилан бүтээгдэхүүний 13.5, төмсний 158.8, хүнсний ногооны 154.3 хувийг тус тус хангахуйц хэмжээтэй байсан байна.

Газар тариалангийн салбарт үр тарианы бүтцэд рапс, гурвалжин будаа, арвай нэмэгдсэн, хүнсний ногооны үйлдвэрлэл тогтвортой өсөж, нэр төрөл олширсон, бага оврын техник, тоног төхөөрөмжийн ашиглалт нэмэгдэж байгаа, жимсний үйлдвэрлэл сэргэж эхэлсэн, төмсний болон зарим ногооны үр үйлдвэрлэж байгаа зэрэг нааштай үзүүлэлтүүд байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын нөлөө ихэссэн, тариалан эрхэлж буй нэгжүүдийн хөрөнгө санхүүгийн чадавхи суларсан, мэргэшсэн ажилтан, мэргэжилтний тоо цөөрсөн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж, тариалангийн нийт талбайн дөнгөж 30.0 хувийг ашиглаж байна.

Түүнчилэн газар тариалангийн салбарт техник, технологийн шинэчлэлт хийх, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулан, үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, хангамжийг сайжруулах, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага тавигдаж байна.

5.1.1. Үр тарианы үйлдвэрлэлийн өнөөгийн байдал: Дархан-Уул аймагт үр тарианы үйлдвэрлэлийг атрын анхны аж ахуй болох Хонгор суманд эрхэлсээр ирлээ. Аймгийн газар тариалангийн салбарын хөгжлийн түүхэнд 1988 онд 17.5 мянган га-д үр тариа тариалж, 32.2 тонн улаан буудай хурааж, нэг га-аас 18.1 цн ургац авч байсан хамгийн өндөр амжилт байлаа.

Хонгор сумын хэмжээнд үр тарианы 31.2 мян.га талбайг 37 аж ахуйн нэгж, 57 иргэн гэрээгээр эзэмшиж байгаа боловч 2007 онд үр тарианы 9.4 мян.га талбайд тариалалт хийж, 4.7 мян.га-г уринш, цэвдэгшээр боловсруулж, 17.2 мян.га талбайг ашиглалтгүй өнжөөж, атаршуулсан байна.

5.1.2. Төмс, хүнсний ногооны салбарын өнөөгийн байдал: Дархан-Уул аймаг нь төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлээр улсад тэргүүлэх байрыг эзэлдэг бөгөөд 2007 оны ургацын дүнгээр төмсний үйлдвэрлэлтээр улсын ургацын 4.9, бүсийн ургацын 8.7, хүнсний ногооны үйлдвэрлэлтээр улсын ургацын 12.1, бүсийн ургацын 19.7 хувийг тус тус эзэлж байна.

Монгол улсын Засгийн Газраас хэрэгжүүлсэн “Ногоон хувьсгал” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэнээр өрхийн тариалан эрхлэгчдийн тоо 10.0 гаруй мянгад хүрч, тариалах талбай нэмэгдэж, нийт ургацын хэмжээ өсч, хүн амын төмс, хүнсний ногоогоор өөрийгөө хангах түвшинг нэмэгдүүлэн, өрхийн бодит орлого дээшилсэн байна. 2007 онд аймгийн хэмжээгээр 654.8 га-д төмс, 700.07 га-д хүнсний ногоо тариалж, 5.7 мянган тонн төмс, 9.2 мянган тонн хүнсний ногоог хураан авсан нь 1980-аад онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 4 дахин, хураан авсан ургацын хэмжээ 2 дахин өссөн байна.

Төмс, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийн хувьд сүүлийн жилүүдэд сэргэх хандлагатай байна.

Дархан-Уул аймагт байцаа, шар манжин, шар лууван, хэмх, лооль, сонгино, сармис, хулуу, навчит үнэрт ногоо зэрэг 8 төрлийн ургамлыг голлон тариалж байна.

Тариалах ургамлын бүтцэд нилээд өөрчлөлт орж байна. Тухайлбал 20-оод жилийн өмнө хүнсний ногоо тариалах талбайн 90 хувийг байцаа, 3.0 хувийг шар манжин эзэлж байсан бол одоо 13.9 хувийг байцаа, 63.3 хувийг шар лууван, 3.0 хувийг хэмх, 1.8 хувийг лооль, 10.7 хувийг сонгино, 3.6 хувийг бусад ногоо эзлэх болсон байна.

Хүнсний ногооны нийт үйлдвэрлэлийн хэмжээгээр хүн амын хэрэгцээг бүрэн хангаж байгаа хэдий ч нэр төрлийн хангамжийн хувьд харилцан адилгүй тухайлбал, байцаа, манжин, сармисны хэрэгцээний 17.2-67.5 хувийг хангаж байна.

Иймээс орон нутгийн үйлдвэрлэлийн бололцоотой бүхий л чиглэлээр хүнсний ногооны нэр, төрлийг олшруулан, тариалалтыг шатлан нэмэгдүүлэх явдал чухал байна.

Сүүлийн жилүүдэд, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн усан хангамжийг сайжруулах, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, таримлын нэр төрлийг олшруулах, бага оврын трактор, усалгааны системийг ашиглах замаар бүтээмжийг дээшлүүлэн эрчимжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч байгаа боловч “Ногоон хувьсгал,” хөтөлбөр хэрэгжиж эхлэхийн өмнө төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд мэргэжлийн томоохон аж ахуйн нэгжүүд зонхилж байсан бол эдүгээ жижиг хувийн үйлдвэрлэгчид болон өрхийн тариалан буюу мэдлэг, туршлага, эрчимжүүлэлт багатай үйлдвэрлэл зонхилох болсонтой холбоотойгоор сүүлийн жилүүдэд агротехнологи их зөрчигдөж байгаагаас нэг га-аас авах ургацын хэмжээ тогтвортой нэмэгдэхгүй байна.

5.1.3. Зоорь, хүлэмжийн аж ахуйн өнөөгийн байдал: Судалгаагаар Дархан-Уул аймгийн хэмжээгээр 10800 гаруй тонн ногоо хадгалах хүчин чадал бүхий 710 гаруй зоорь байна. Эдгээр зоорийн аж ахуйн 30.0 гаруй хувь нь иж бүрэн механикжсан технологийн зоориуд байгаа боловч зах, зээлийн нөхцөлд өртөг, зардлаа даахгүй болон хувьчлалын дүнд бий болсон аж ахуй, зохион байгуулалтын байдлаас шалтгаалан бүрэн ашиглагдахгүй байсаар байна.

Хураан авч байгаа ургацын хэмжээ, хүн амын хэрэгцээ нь зоорины аж ахуйг хөгжүүлэх бүрэн боломж байгааг үндэслэл болгож “Зоорь” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлээ.

Аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг төмс, хүнсний ногоогоор бүрэн хангахуйц үйлдвэрлэл явуулж байгаа хэдий ч ногоог технологийн дагуу хадгалах зоорь, агуулахын аж ахуйн эзэмшил, хувьчлалын зохион байгуулалттай холбоотойгоор зах зээлд нийлүүлэгдэх төрөл бүрийн ногооны хангамж жигд биш, ногоочид хураалтын үедээ хямд өртгөөр ногоогоо борлуулдагаас ашгийн түвшин ихээхэн буурч, энэ хэмжээгээр тэдний амьдралд нөлөөлж байна.

Тус аймгийн хувьд хөрсний бүтэц, гадаргуугийн усны нөөц, нарны энергийг ашиглах боломж, хүн амын хэрэглээний онцлог зэргээс үзэхэд хучлагатай тариалангийн аж ахуйг хөгжүүлэх бүрэн боломж байдаг. 2007 оны байдлаар аймгийн хүн амын хэрэгцээт лоолийн 60.2, хэмхний 84.9 хувийг хангахуйц үйлдвэрлэлийг явуулж байна.

Хүлэмжийн аж ахуйн тоо 2002 оноос тогтвортой өсч, одоогоор аймгийн хэмжээгээр 10.6 мянган.м.кв талбай бүхий хүлэмжийг ашиглаж байгаа нь 1990 онтой харьцуулахад тоо хэмжээ нь 2.4 дахин, эзлэх талбай бараг 4 дахин өсчээ. Харин хучлагатай тариалангийн арга технологийг ногоочид бүрэн эзэмшээгүй байгаа, хүлэмжийн технологийн горим зөрчигдөж байгаагаас нэгж талбайгаас хурааж буй ургацын хэмжээ төдийлэн нэмэгдэхгүй байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэлд эзлэх хэмх, лооль бусад таримлын хувийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний ногооны хэрэгцээнд эдгээр ногооны хангамжийг сайжруулахад хучлагатай тариаланг өргөжүүлэх явдал чухал байна.

5.1.4. Жимс, жимсгэний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал: Сүүлийн жилүүдэд ажиглагдаж байгаа тариалангийн салбарын уналт жимсний аж ахуйд бүр ч хүндээр тусаж жимст цэцэрлэгийг шинээр байгуулах байтугай хуучин цэцэрлэгийн арчилгаа орхигдож, нэгэнт бий болсон талбайн хэмжээ буурч, мөн түүнчилэн байгалийн жимс, жимсгэний генийн сан, нөөц багасаж байна.

Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа боловч тэдгээрийн дотроос орон нутагт зохицсон өвөл болон хүйтэнд тэсвэртэй, өвчин хортонд тэсвэр сайн, арвин ургацтай жимс, жимсгэний сортууд цөөн байгаа мөн нийт мод, бутны 60-70 хувь нь хөгширсөн, суулгац гаргах үржүүлгийн газрын хүчин чадал хүрэлцээгүй, техник хуучирсан зэрэг нь гол шалтгаан болж байна.

Дархан-Уул аймагт 2007 онд 36 га газарт жимс, жимсгэнэ тариалж, 7.3 тонн ургац авсан нь аймгийн хүн амын хэрэгцээний дөнгөж 0.1 хувийг хангаж, үндсэндээ импортын жимсээр хүн амын хэрэгцээ хангагдаж байна.

5.2. Газар тариалангийн салбарын зорилго

Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэн нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх, газар ашиглалтыг сайжруулан нийт эргэлтийн талбайг 2 дахин нэмэгдүүлэх замаар аймгийн хүн амын үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангаж, улмаар зах, зээлд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

5.3. Тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт 1. Атаршсан болон ашиглалтгүй талбайг эргэлтэд оруулан, газар ашиглалтын түвшинг 98.0 хувьд хүргэх технологийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Тариалангийн талбайн тооллогыг явуулж, атаршсан талбайг эргэлтэд оруулах аж ахуйн нэгжүүдийг зөв сонгон, тэдгээрт эзэмшүүлэх талбайн хэмжээг Засгийн газраас тогтоосон хэмжээнд байлгах зохион байгуулалтын арга хэмжээг авна.
- Эрдэм шинжилгээний байгууллагаас мөрдлөг болгож буй зурваслан тариалалт, хучлагатай тариалан, цомхотгосон ба механик элдэншүүлэггүй аргаар уриншийн боловсруулалт хийх техник, технологийн нөхцлийг хангахад тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

Тэргүүлэх зорилт 2. Усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийг бүхий л талаар дэмжиж, орон нутгийн онцлогт илүү зохицсон агро-технологи, аж ахуйн зохион байгуулалтыг боловсронгуй болгосноор усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги :

- Усалгаатай тариалангийн шинэ технологийг нэвтрүүлэх санаачилгыг дэмжин, усалгааны зориулалттай техник, тоног төхөөрөмжийг урт хугацаатай, бага хүүтэй зээл /лизинг/-ээр олгоход дэмжлэг үзүүлнэ.
- Голын сав дагуу тариалан эрхлэх боломжтой газар нутгийн хайгуул, судалгаа хийж, Хүйтний гол, Орхон голоос эх авсан усан сан ба гол суваг байгуулах замаар шинээр услалтын системүүдийг барина.
- Хуучин услалтын системүүдийг засварлахад шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгуулан 2 системийг сэргээн ашиглана.
- Цас, борооны усыг хуримтлуулан тариалангийн усалгаанд ашиглах зорилгоор сум бүрт хиймэл нуур, хөв, цөөрмийг байгуулан тариалангийн талбайн усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- Усалгаатай үр тарианы үйлдвэрлэлийг дэмжин 200 га үр тарианы талбайг усжуулна.

Тэргүүлэх зорилт 3. Үр тариа, төмс, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг эрдэм шинжилгээний байгууллага төдийгүй техник, технологи, аж ахуй, санхүүгийн боломжтой нөхцөл бүхий аж ахуйн нэгж, тариалан эрхлэгчдийн бизнесийн сонирхолтой хослуулах замаар сайн чанарын үрийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, үрийн дотоодын хэрэгцээг бүрэн хангана.

Хэрэгжүүлэх стратеги :

- Техник, технологийн боломжтой, үр үйлдвэрлэх сонирхолтой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- Ганд тэсвэртэй сортуудын үр үржүүлгийг өргөтгөхөд төрөөс хөрөнгийн дэмжлэг үзүүлэх хэмжээг нэмэгдүүлнэ.
- Усалгаатай, бордоотой нөхцөлд эрчимтэй ургах үр тариа, тэжээл, техникийн ургамлын сортуудыг судалж, сонгон шалгаруулж, тариалах технологийн хамт импортлох замаар нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх, үүнд шаардагдах хөрөнгийг улсын төсвөөр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
- УГТСЭШХ-ийн үйлдвэрлэж буй вирусгүй үрийн төмс, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Төмсний салбарыг сэргээн сайжруулах” төслийн хүрээнд шинэ сортын төмсний үрийг үржүүлж буй аж ахуйн нэгж, иргэдийн ургацад урамшуулал олгон дэмжинэ.
- Богино хугацаанд түргэн боловсордог сортын үрийг өргөн хэрэглэж, таримлын нэр төрлийг олшруулна.
- УГТСЭШХ-д хүнсний ногооны голлох таримлын үр үйлдвэрлэлийг өргөжүүлсэнээр улсын үрийн хэрэгцээг хангана

Тэргүүлэх зорилт 4. Өрхийн тариаланг өргөжүүлэн, эрчимжүүлэн хөгжүүлж, “Ногоон хувьсгал” 2 дахь шатны хөтөлбөрийн зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Өрхийн тариаланд ээлжлэн тариалах системийг нэвтрүүлэн хөрс болон таримлыг хамгаалах ажлын чанарыг сайжруулна.
- Өрхийн тариалангийн гар ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийг импортлохын зэрэгцээгээр дотооддоо үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг дэмжинэ.
- Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг нэгж, өрхүүдэд боломжтой бүх нөхцлөө ашиглан худаг, гол, цас, борооны усыг хэмнэлттэй зарцуулах арга технологийг эзэмшүүлнэ.
- Хүнсний ногооны таримлын бүтцийг олшруулан, сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.
- Сумдын Агропаркуудыг бэхжүүлэн, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

Тэргүүлэх зорилт 5. Хөрсний элэгдэл, чийгийн хангамж, гангийн давтамж, хөрсний үржил шимийн бууралт зэрэг хөрс, цаг уурын өнөөгийн нөхцөл, байдалд тохирсон дэвшилтэт технологид нийцсэн техникийн шинэчлэлийн бодлогыг тууштай баримтална.

Хэрэгжүүлэх стратеги:

- Бага, дунд оврын техник, тоног төхөөрөмжийг импортоор оруулах эрх бүхий аж ахуйн нэгж, иргэдийг дэмжиж, тариалан эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэх ажлыг эрчимжүүлэхийн зэрэгцээгээр дотоодод угсарсан техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгоход дэмжлэг үзүүлнэ.
- Аймагт “Хөдөө аж ахуйн техникийн засвар, үйлчилгээний төв”-ийг байгуулан ажиллуулах боломжийг судлан хэрэгжүүлнэ.
- Хөдөө аж ахуйн техникийн сэлбэгийн хангамжийг сайжруулан, борлуулалтын цэгүүдийг ажиллуулна.
- Үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдэд өндөр хүчин чадлын трактор, комбайн, үр цэвэрлэгээний машин, үрийн агуулах, бордоо, ургамал хамгааллын бодис, услалтын системийн тоног төхөөрөмж худалдан авахад нь хөнгөлөлт үзүүлэх ажлыг зохион байгуулна.

Тэргүүлэх зорилт 6. Байгаль орчинд халгүй аргаар ургамал хамгаалах болон хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг өргөтгөнө.

Хэрэгжүүлэх стратеги:

- Эрдэс болон органик, био бордооны үйлдвэрлэл, хэрэглээг өргөжүүлэх замаар хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах ажлын түвшинг дээшлүүлнэ.
- Чанар, стандартын шаардлага хангасан ургамал хамгаалах бодисыг нийлүүлэхийг төрийн бодлогоор зохион байгуулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Байгаль орчин, бүтээгдхүүний чанарт сөрөг нөлөөгүй аргаар тариалангийн талбайн хог ургамал, хортонтой тэмцэх ажлыг дэмжинэ.
- УГТСЭШХ-г түшиглэн ризобактери болон биобордоо үйлдвэрлэх цехийг байгуулан, бордооны хэрэгцээг бүрэн хангана.
- УГТСЭШХ-ийн Хөрс, агрохимийн лабораторид тариалангийн талбай бүрээр хөрсний үржил, шимийг тогтоох шинжилгээг хийсний үндсэн дээр гарсан зөвлөмжийг тариалан эрхлэгчдэд хүргүүлэн мөрдөн ажиллана.

Тэргүүлэх зорилт 7. Хамгаалагдсан хөрсний буюу шилэн, нийлэг хальсан хүлэмж, дарлага, туннелийн аж ахуйг дагнан эрхлэх явдлыг дэмжин, зоорь, агуулахын аж ахуйн технологийн түвшинг сайжруулан хүртээмжийг нэмэгдүүлсэнээр хүнсний ногооны хэрэглээний бүтэц, жилийн тогтвортой хангамжид чанарын өөрчлөлт гаргана.

Хэрэгжүүлэх стратеги :

- “Зоорь”, “Хүлэмж” 2 дахь шатны аймгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулан, хэрэгжүүлнэ.
- Нарны энерги, газрын нөөц, боломж өгөөжийг зохистой ашиглан, хучлагатай нөхцөлд далд хөрсний хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар эрт ургацын шинэ ногоог зах зээлд хүрэлцэх хэмжээгээр тасралтгүй нийлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
- Далд хүнсний ногооны болон хүлэмжийн аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж, ялангуяа хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, бэлтгэхэд туслана.
- Хүлэмжийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай техник, технологи, үр материалаар хангах арга хэмжээг төлөвлөн, сумдын агропаркуудын хүлэмж, зоорийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Орчин үеийн шаардлагад нийцсэн автомат удирдлагатай, механикжсан хөргүүртэй, өндөр хүчин чадалтай хүнсний ногооны зориулалтын агуулах бүхий зах байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Тэргүүлэх зорилт 8. Жимс, жимсгэний аж ахуйг өргөжүүлэн хөгжүүлэх замаар хүн амын хүнсний бүтэц дэхь жимс, жимсгэний хэрэглээг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги :

- Жимс, жимсгэнэ, чимэглэлийн ургамлын суулгацыг ургуулах үржүүлгийн газрыг байгуулах үүсгэл, санаачилгыг дэмжинэ.
- Бүлэг, хоршоо зохион байгуулж, хамтын цэцэрлэг үүсгэн байгуулах хөдөлгөөнийг өрнүүлнэ.
- Хувийн орон сууцтай айл, өрхүүдийн жимс, жимсгэний ургамлыг тарьж, ургуулах сонирхлыг нэмэгдүүлэн, арга технологид сургаснаар амины орон сууцанд амьдардаг айл өрхүүдийн жимс, жимсгэнэ тариалах хөдөлгөөнийг дэмжинэ.

5.4. Хүрэх үр дүн

Хөгжлийн 1 дүгээр үе шатанд /2008-2012 он/:

“Атрын 3 дахь аян”-ы зорилтыг бүрэн хэрэгжүүлэн үр тарианы үйлдвэрлэл сэргэн тогтворжиж, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрчимжилтийн түвшин нэмэгдэнэ.

- Атаршсан 18.5 мянган га талбайг эргэлтэд оруулсанаар тариалангийн талбайн ашиглалт 28.8 мянган.га-д хүрч, 2007 онтой харьцуулахад 93.6 хувиар өснө.
- Уриншийн боловсруулалт 15.0 мянган.га-д хүрч, уриншлах талбай 4 дахин нэмэгдэнэ.
- Тариалах талбайн хэмжээ 26.8, хураан авах ургацын хэмжээ 75.5 хувиар тус тус өснө.
- Хүн амын хэрэгцээт үр тарианы 95.1 хувийг хангаж, хангалтын түвшинг 6.4 дахин нэмэгдүүлэхийн зэрэгцээ төмс, хүнсний ногоогоор бүрэн хангана.

Хөгжлийн 2 дугаар үе шатанд /2013-2021 он/:

Тариалангийн үйлдвэрлэл бүрэн тогтворжиж, байгаль цаг уурын нөлөөллөөс хамаарахгүйгээр иргэд дотоодын үр тариа, төмс, хүнсний ногоогоор бүрэн хангагдаж, тариалан эрхлэгчид аж ахуй, санхүүгийн хувьд бүрэн бие даасан, эрчимжсэн аж ахуйнууд үйл ажиллагаа явуулж байх болно.

- Нийт 19.5 мянган га талбайг эргэлтэд оруулсанаар эргэлтийн талбайн 98.0 хувь буюу 30.0 мянган га талбайг ашиглах боломж бүрдэнэ.
- 1 га-аас авах ургацын хэмжээг тогтворжуулан, 2007 онтой харьцуулахад үр тарианы ургацыг 23.5, төмсний ургацыг 26.3, хүнсний ногооны ургацыг 10.6 хувиар тус тус нэмэгдүүлнэ.
- Үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэнээр буудай, төмсний үр, жимс, жимсгэний суулгацын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.
- Хүн амын хэрэгцээт үр тариа, төмс, хүнсний ногоог өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангана.

Зургаа. Мал аж ахуйн салбарын хөгжил, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн.

6.1. Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал

Дархан-Уул аймгийн хэмжээгээр 2007 оны жилийн эцэст 2282 малтай өрх, 976 малчин өрхөд 230.4 мянган толгой мал тоологдсон нь өмнөх жилтэй харьцуулахад 27.9 хувиар өсөж, 1990 онтой харьцуулахад 2.1 дахин нэмэгдсэн байна. Малтай нэг өрхөд 101 толгой мал ноогдож байгаа нь 1990 онтой харьцуулахад 3.8 дахин нэмэгдсэн байна.

Малын өсөлтөд хэдийгээр механик өсөлт нөлөөлж байгаа боловч аймгийн мал аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтүүд сайжирч, мал сүрэг биологийн тогтвортой өсөлтөөр өсөж байна. Тухайлбал, 2007 онд оны эхний 100 хээлтэгчээс 97 толгой төл бойжуулсан нь улсын дунджаас 10 төлөөр илүү, оны эхний том малын 0.16 хувь нь зүй бусаар хорогдсон нь улсын дунджаас 3.2 дахин бага байна.

Малын тэжээлийн хангамж сайжирч, нэг хонин толгойд 45-55.6 кг тэжээл нэгж тэжээл бэлтгэж байгаа нь улсын болон бүсийн дунджаас 4.5-6.5 дахин илүү байна.

Малын тоо толгой өсөж байгаа боловч зах зээлийн нөхцөл, тэжээлийн хүрэлцээ, малчдын бизнесийн сонирхол зэргээс шалтгаалан мал аж ахуйн технологийн зөрчлүүд гарч, сүргийн зохистой бүтэц алдагдсан байна. Нийт сүрэгт эзлэх бод малын тоо толгой жилээс жилд буурч 2007 онд дөнгөж 15.0 хувийг эзлэх болсон нь 1990 онтой харьцуулахад 55.5 хувиар буурсан байна. Мөн нийт сүргийн 40.7 хувийг ямаа эзлэх болсон нь 1990 оноос 5.5 дахин өссөн байна.

Аймгийн мал сүргийн генийн чадавхи сайжирч 2007 оны байдлаар 21 үүлдэр, омог, хэвшлийн 47.8 мянган толгой цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилмэл омгийн мал бүртгэгдсэн нь нийт малын 20.7 хувийг эзэлж байна.

Мал аж ахуйд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дүнд үйлдвэрлэл сэргэж байгаа боловч бэлчээрийн даацын хэтрэлт, мал аж ахуйн материаллаг баазын хангалтгүй байдлаас болж таваарлаг мал аж ахуйн зохистой хэлбэр бий болж чадахгүй, малаас авах ашиг шим нэмэгдэхгүй байна.

Эрчимжсэн мал аж ахуйн өнөөгийн байдал. Манай улсын хотжих үйл явц улам гүнзгийрэхийн зэрэгцээ эдгээр хотуудын хүн амыг хүнсээр хангах зорилгоор таримал тэжээлийн үйлдвэрлэл эрхлэх боломжтой бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх зорилтын дор тус аймагт эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн бааз суурь тавигдаж, саалийн механикжсан ферм 2, 100 мэгжний

гахайн ферм, нарийн, нарийвтар ноост хонины 5 цогцолборт эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг технологийн дагуу эрхэлж, эдгээрт сүүний чиглэлийн 1000 гаруй үнээ, 25.0 мянга гаруй толгой нарийн, нарийвтар ноост хонийг өсгөж, гахайн тоо толгойг 17.0 мянган толгойд хүргэж, хүн амын хүнсний бүтээгдхүүний хангамжинд онцгой үүрэг гүйцэтгэж байлаа.

Хүн ам ихээр төвлөрөн суурьшсан хот газарт зайлшгүй хэрэгцээтэй байсан эрчимжсэн мал аж ахуйн цогцолборууд зах зээлийн нөхцөлд өртөг, зардлаа даахгүйгээс уналтанд орж, тараан жижиглэж, хувьчилсан боловч тэдний эрчимжилтийг хангаж байсан нөхцлийг хэвээр хадгалж чадаагүй, үржлийн эх сүрэг болон тэжээлээр хангах, мэргэшсэн ажилчин, мэргэжилтэнг ажиллуулах боломж бага байснаас эрчимжсэн аж ахуйн аятай хэлбэр бүрдэж чадаагүй нь дээрх аж ахуйдыг уналтанд хүргэж, арвин ашиг шимт цэвэр, эрлийз үүлдрийн малын тоо эрс буурсан юм.

1990 онд аймгийн нийт малын 20.3 хувийг цэвэр, эрлийз үүлдрийн мал эзэлж байсан бол 1995 онд дөнгөж 4.1 хувийг эзлэх болсон билээ.

Хүн амын хүнсний хангамжинд онцгой ач холбогдол бүхий гахай, шувууны аж ахуйд өсөлт, төлөрхөг чанараар муу, давжаа гахай, амьдрах, өндөглөх чадвараар муу шувуу сүрэгт зонхилон, олон найрлагат тэжээлийн үнэ өсч, ховордсоноос эдгээр аж ахуйдын үр өгөөж муу байна.

Эрчимжсэн технологитой аж ахуйдыг хөгжүүлэх чиглэлээр эхлэлүүд тавигдсан бөгөөд одоогоор аймгийн хэмжээнд сүүний үхрийн 22, махны үхрийн 3, махны хонины 1, нарийн, нарийвтар ноост хонины 2, зөгийн 3, гахай, тахианы 10 нийт 40 гаруй фермерүүд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хүчин зүйлүүд болох арвин ашиг шимт үржлийн малын болон тэжээлийн баттай бааз суурь, найдвартай цахилгаан хангамж, тээврийн хэрэгслэл ба хөдөлгөөнт төхөөрөмжийн хангамж, усан хангамжийг бий болгох, мал аж ахуйг механикжуулан, үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх, мал эмнэлэг, үржлийн мэргэжлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зэрэгт чиглэгдсэн хөрөнгө, санхүү, технологийн цогц арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байгаа юм.

6.2. Мал аж ахуйн салбарын зорилго

Бүс нутгийн хэмжээнд бэлчээрийн малын тоог цөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлийг газар тариалантай зөв хослуулан, эрчимжүүлэн хөгжүүлсэнээр бэлчээрийн даацад тохирсон, суурин, хагас суурин хэлбэрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн загварт шилжүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн, хүн амын хүнсний хэрэгцээг хангана.

6.3. Тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

Тэргүүлэх зорилт 1. Бэлчээрийн малын тоо, толгойг бууруулах эрх зүй, бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийг бууруулан, сүргийн зохистой бүтцийг хангана.

Хэрэгжүүлэх стратеги:

- Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болгох хуулийн төсөлд оновчтой саналуудыг оруулан шийдвэрлүүлэх.

- Бэлчээрийн мал бүхий иргэдийн шилжилт, хөдөлгөөнийг багасгах чиглэлээр холбогдох аймгууд, малчид, иргэд, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.
- Бэлчээрийн малыг өсгөх зохистой бүтэц, малын тоо толгойн хэмжээг тогтоон, аймгийн нутаг дэвсгэрт мөрдүүлэх арга хэмжээг авах.
- Дархан сумын нутаг дэвсгэрийг бүхэлд нь бэлчээрийн малгүй бүс нутаг болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Тэргүүлэх зорилт 2. Газар тариалантай зөв хосолсон эрчимжсэн мал аж ахуйн зохистой бүтэц бүхий загвар аж ахуйн тоог нэмэгдүүлэн, бүсчилэн хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Орон нутгийн онцлогт тулгуурлан Дархан суманд хот орчмын сүүний, махны үхэр, гахай, шувууны аж ахуйдыг, Хонгор суманд мах-ноосны хонины, сүүний болон махны үхрийн, гахай, шувууны, Орхон суманд сүүний үхрийн, сүүний ямааны, гахай, шувууны, Шарын гол суманд сүү, махны үхрийн, мах-ноосны хонины, гахайн аж ахуйдыг тус тус хөгжүүлэх чиглэлийг тогтоосны үндсэн дээр эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бүс нутгийг тодорхойлон аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулна.
- Газар тариалантай зөв хосолсон, эрсдэл багатай эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн оновчтой хэлбэр, малын төрөл, тоо хэмжээний зохистой бүтэц бүхий аж ахуйдыг бий болгоход дэмжлэг үзүүлэн, сурталчилсанаар загвар аж ахуйдын тоог нэмэгдүүлнэ.
- Эрчимжсэн мал аж ахуйг технологийн зохистой хэмжээгээр эрхлэхэд иргэн, аж ахуйн нэгжүүдэд шаардагдах эдлэн, бэлчээр, хадлангийн талбайг хууль тогтоомжид нийцүүлэн давуу эрхээр эзэмшүүлэн, таримал тэжээл, ногоон тэжээл, даршны ургамлыг тариалахад нь дэмжлэг үзүүлнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд шинэ арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллагуудад судалгаа, шинжилгээний захиалга өгч, хамтран ажиллана.
- Шинээр барих хашаа, байрны зураг, төсөл, түүнд тавих шаардлагыг орон нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохируулан боловсруулж, малчдад зөвлөмж болгон хүргүүлнэ.

Тэргүүлэх зорилт 3. Мал аж ахуйд биотехнологийн ололтыг нэвтрүүлж, мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар малын үржлийн чанарыг сайжруулсанаар ашиг шимийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Аймгийн “Малыг үржүүлэх селекцийн төлөвлөлт”-ийг боловсруулан мөрдөж ажиллах ба арвин ашиг шимт малыг нутагшуулан хэрэгцээний буюу “цус шингээх” эрлийзжүүлэг хийж, ашиг шимээр давуу эрлийз малыг бий болгох замаар сүү болон сүү-махны үхэр, мах-ноосны чиглэлийн хонь, ноолуур-махны чиглэлийн ямаа, мах-өөхний чиглэлийн гахай, өндөг-махны чиглэлийн шувууны тоо толгойг өсгөнө.
- Аймагт үржлийн мал бойжуулан худалдах зорилго бүхий бүхий бааз аж ахуйг байгуулсанаар хээлтэгч, хээлтүүлэгчийн зохистой харьцааг хангана.
- Арвин ашиг шимт мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үрийг авах, иргэд, аж ахуйн нэгжийн хооронд үржлийн материал солилцох, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлыг бодлогын хэмжээнд зохион байгуулна.
- Мэргэжлийн болон Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран малын нөхөн үржих биологийн нөөцийг бүрэн ашиглах, эрчимжүүлэх, ашиг шимийг

нэмэгдүүлэхэд чиглэгдсэн мал хээлтүүлгийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх боломжийг судлан, туршин нэвтрүүлнэ.

- Малчид, фермерүүдэд орон нутгийн болон бүсийн зах зээлд үйлчилдэг цэвэр, эрлийз үүлдрийн үржлийн малын үржүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх.

Тэргүүлэх зорилт 4. Гахай, шувуу болон тэжээвэр амьтдын аж ахуйгаас авах үр, өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө, санхүүгийн болон технологийн асуудлыг шийдвэрлэснээр гахай, шувууны мах, өндөг, зөгийн балны үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэн хүнсний нөөцийг бий болгоно.

Хэрэгжүүлэх стратеги :

- Гахай, шувуу, зөгийн аж ахуйг эрхлэх чиглэлээр технологийн сургалтуудыг зохион байгуулна.
- Тэжээвэр амьтдын аж ахуйг боловсруулах үйлдвэрийн хамт хөгжүүлэхэд нь техник, технологийн дэмжлэгийг үзүүлнэ.
- Үржлийн гахай, шувууны аж ахуй эрхлэгчдийг дэмжин, мах-өөхний чиглэлийн гахай, өндөг-махны чиглэлийн шувууг импортоор оруулан хангах ажлыг зохион байгуулна.
- Зөгийн аж ахуй эрхлэгчдэд бэлчээрийг эзэмшүүлэх, бэлчээрт үндсэн сайжруулалт хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.

6.4. Хүрэх үр дүн

Хөгжлийн 1 дүгээр үе шатанд /2008-2012 он/:

Газар тариалантай зөв хосолсон эрчимжсэн мал аж ахуйдын тоо өсөж, бүс нутгийн бэлчээрийн даацад тохирсон хагас суурин хэлбэрийн мал аж ахуйн хэв шинж бүрдэнэ.

- Малын тоо толгой 25.6 хувиар өсөж, нийт сүрэгт хээлтэгчийн эзлэх хувийн жин технологийн хэмжээнд хүрнэ.
- Бэлчээрийн малын тоо, толгойг 30.0 хүртэл хувиар бууруулан, цэвэр, эрлийз болон нутгийн шилмэл омгийн малын тоо 80.0 мянгад хүрч, нийт сүрэгт эзлэх хувь хэмжээ нь нэмэгдэнэ.
- Хүн амын хэрэгцээт мах, махан бүтээгдхүүний 49.7, сүү, сүүн бүтээгдхүүний 87.5, өндөгний 15.9 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах болж хангамжийн түвшин сайжирна.

Хөгжлийн 2 дугаар үе шатанд /2013-2021 он/:

Малчин өрхийн 40-өөс доошгүй хувь нь хагас суурин, суурин амьдралын хэв шинжид шилжиж, бэлчээр нутгаа зохистой ашиглаж эхлэхийн зэрэгцээ малын ашиг шимийг үүлдрийн стандартын түвшинд хүргэснээр бүтээгдхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ нэмэгдэж, малчдын бодит орлого нэмэгдэнэ.

- Мал сүрэг биологийн тогтвортой өсөлтөөрөө өсөж, сүргийн бүтцэд чанарын өөрчлөлт гарна.
- Бэлчээрийн малын тоо толгойг 60.0 хүртэл хувиар бууруулан, цэвэр, эрлийз болон нутгийн шилмэл омгийн малын тоо 160.0 мянгад хүрч, нийт сүргийн 50.0 орчим хувийг эзлэх болно.
- Хүн амын хэрэгцээт мах, махан бүтээгдхүүний 62.4 хувийг, өндөгний 63.3 хувийг, сүү, сүүн бүтээгдхүүний хэрэгцээг бүрэн хангана.

Долоо. Хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн үйлчилгээний өнөөгийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

7.1. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний өнөөгийн байдал

Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг Мал эмнэлгийн болон Мал үржлийн алба мэргэжлийн үндсэн удирдлагаар ханган, хэрэгжилтийг хувийн хэвшлийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэн ажиллаж байна.

Одоогоор аймгийн хэмжээнд 12 мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгж үйл ажиллагаагаа албан ёсоор явуулж байгаагаас 2 нэгж нь зөвхөн мал эмнэлгийн эмийн сангийн, 10 нэгж нь мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг эрхлэн явуулж байна.

Нэг үйлчилгээний нэгжид дунджаар 23.0, нэг малын эмчид дунджаар 13.5 мянган толгой мал ноогдож байгаа нь бусад аймгуудын дунджаас доогуур байгаа ба мал эрүүлжүүлэх болон мал үржлийн ажил, үйлчилгээг нутаг дэвсгэрийн хэмжээнд жигд, хүртээмжтэй, шуурхай хүргэх давуу талтай.

Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, толгой, түүнд шаардагдах эм, био бэлдмэлийн захиалгыг аймгийн бодит хэрэгцээг хангахуйц хэмжээнд хүргэж нэмэгдүүлэн улсын хөрөнгө оруулалтаар жил бүр 50.0 гаруй сая төгрөгний эм, биобэлдмэлийг авч, энэхүү арга хэмжээг хэрэгжүүлсэн МЭҮ-ийн үйлчилгээний анхан шатны нэгжүүдэд 20.0-30.0 сая төгрөгний санхүүжилтыг олгож байна.

Сүүлийн жилүүдэд боом, цусан халдварт, дуут хавдар, галзуу, гахайн цусан халдварт зэрэг байгалийн голомтот халдварт өвчнүүд гараагүй бөгөөд паразит өвчний гаралт 40.0 гаруй хувиар буураад байна.

Мал эмнэлгийн лабораторийн оношлох чадавхийг бэхжүүлэх зорилгоор ХХААЯ-ны дэмжлэгтэйгээр ийлдэс судлалын лабораторийг 2007 онд байгуулан гадаадын төслүүдийн хөрөнгө оруулалтаар тоноглон, тохижуулж байна.

Мал үржлийн ажил, үйлчилгээг мөн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээ хийх замаар гүйцэтгүүлж байгаа бөгөөд жил бүр нийт хээлтүүлэгч малыг аттестатчилан, жишигт тэнцүүлэх, бог малын хээлтүүлэгчийг тусгаарлан суурилах, малын ашиг шимийн түвшинг тогтоох, шилмэл мал шалгаруулах зэрэг ажлуудыг хийж байна.

Мал үржил, мал маллагааны ажлын технологийн алдаанаас болж жил бүр нийт хээлтэгч малын 5.0-14.0 хувь нь хээл хаяж, сувайрч байгаагаас энэ хэмжээний төл авах боломжийг алдаж байна. 2007 оны байдлаар 1 азарганд 10 гүү, 1 буханд 47 үнээ, нэг хуцанд 42 эм хонь, 1 ухнад 41 эм ямаа ноогдож байгаа нь хээлтэгч, хээлтүүлэгчийн зохистой харьцаа алдагдахад хүргэж байна.

Мал аж ахуйг үр өгөөжтэй эрхлэх, мал сүргийн биологийн тогтвортой өсөлтийг хангаж, таваарлаг чанарыг нэмэгдүүлэхэд мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, үйлчилгээний чанарыг сайжруулах, төрөөс энэ салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалтыг үр ашгийг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна.

7.2. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний зорилго, тэргүүлэх зорилтууд, хүрэх үр дүн

7.2.1. Мэргэжлийн ажил, үйлчилгээний зорилго: Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, мал үржлийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах замаар халдварт, паразиттах өвчнөөс эрүүлжүүлж, малын генийн чадавхийг сайжруулан, мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг ханган, малын ашиг шим, таваарлаг чанарыг нэмэгдүүлнэ.

7.2.2. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги

Тэргүүлэх зорилт 1. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн нэгжүүдийг бэхжүүлэх, үйлчилгээний нэгжийн стандартын түвшинд бүрэн хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги :

- Мал эмнэлгийн төрийн захиалгат ажил, үйлчилгээний хөлсийг хуульд заасны дагуу орон нутгийн төсөвт бүрэн тусгаж, үйлчилгээний нэгжүүдэд санхүүжүүлэх ажлыг тогтмолжуулна.
- Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагааг аттестатчилан, 2 дугаар зэргээс дээш зэрэглэлд бүрэн хамруулна.
- Малын эмч, мал зүйч нарыг үе шаттайгаар сургалтанд хамруулан, мэргэжлийг нь дээшлүүлнэ.
- Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдээс үзүүлэх үйлчилгээний төрлийг олшруулан, малын халдваргүй өвчний эмчилгээ, мэс засал, жижиг амьтны эмчилгээ бүхий нэгжүүдийн үйл ажиллагаанд түлхүү дэмжлэг үзүүлнэ.

Тэргүүлэх зорилт 2. Мал эмнэлгийн арга хэмжээнд зориулан төрөөс олгож байгаа хөрөнгийг үр ашигтай зарцуулж, мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги :

- Мал, амьтдын өвчлөл, хорогдлын түвшин, лабораторийн оношийн баталгаажилтыг үндэслэн бүртгэгдсэн өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дэд хөтөлбөрүүдийг боловсруулан, хэрэгжүүлнэ.
- Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, толгой, түүнд шаардагдах эм, бэлдмэлийн төлөвлөгөөг хүрсэн түвшингээс бууруулахгүйгээр жил жилийн малын тооны өсөлттэй уялдуулан, төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг үнэлгээг зах, зээлийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн тогтоож, батлуулан, мөрдүүлнэ.
- Малыг паразиттах өвчнөөс сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг малчид иргэдэд хариуцуулан, чанарын баталгаат, зөвшөөрөгдсөн эм, бэлдмэлээр хангахад төрийн зохицуулалттай арга, механизмыг хэрэглэнэ.
- Мал бүхий аж ахуйн нэгж, иргэдийг “Малын эрүүл мэндийн дэвтэр”-ийн бүртгэлийн системд бүрэн нэвтрүүлж, малын шилжилт, хөдөлгөөнийг байнгын хяналтанд авах нөхцлийг бүрдүүлнэ.
- Малыг гоц халдварт, халдварт өвчнөөс сэргийлэх бэлэн байдлыг хангахад чиглэгдсэн асуудлыг төлөвлөн, хэрэгжүүлнэ.

Тэргүүлэх зорилт 3. Гадаад орнуудаас хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтээр Мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээний лабораторийн чадавхийг бэхжүүлэн, малын өвчнийг орон нутагтаа оношлох, мал аж ахуйн гаралтай бүтээгдхүүнд чанарын хяналт хийх боломжийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги :

- Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслийн хүрээнд Мал эмнэлгийн нян, ийлдэс, паразит судлалын лабораторийг байгуулан, итгэмжлэгдсэн лабораторийн түвшинд хүргэнэ.

- Солонгос улсын “Койка” олон улсын байгууллагын санхүүжилтээр Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийг шинээр байгуулна.
- Мэргэжлийн болон хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж, мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдхүүнийг шинжилгээнд бүрэн хамруулахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэн, үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулна.
- “Бруцеллёз”, “Адууны ям” аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, 2010 онд үхэр, хонь, ямааны бруцеллёз, адууны халдварт цус багадаалт өвчнөөс, 2012 оноос адууны ям өвчнөөс бүрэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тэргүүлэх зорилт 4. Мал үржлийн үйлчилгээ эрхлэх үүсгэл, санаачилгыг дэмжин, зохистой хэлбэрээр ажиллуулан, мал үржлийн ажлын хамрах хүрээг өргөтгөнө.

Хэрэгжүүлэх стратеги :

- Аймгийн “Малын үржлийн ажлын чанарыг сайжруулах” дэд хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлнэ.
- Мал аж ахуйн үржлийн албаны болон шилмэл сүрэг, гойд ашиг шимт малын үржлийн ажилтай холбогдсон зардлыг зохих хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- Аймагт “Малын үржил, биотехнологийн лаборатори”-ийг байгуулна.
- Цэвэр, эрлийз үүлдрийн болон үржлийн шилмэл хэсгийн малыг үржлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.
- Орон нутгийн болон гадаадын төслийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр нийт бод мал, үржлийн малыг ээмэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Сум бүрт зохиомол хээлтүүлгийн цэгийг байгуулан бод, бог малын хээлтүүлгийн ажлыг эрчимжүүлнэ.
- Махны хонь, сүүний ямаа, мах, сүүний чиглэлийн үхэрт үр хөврөл шилжүүлэн суулгах биотехнологийн аргыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран туршин хэрэгжүүлнэ.

7.3. Хүрэх үр дүн

Хөгжлийн 1 дүгээр үе шатанд /2008-2012 он/:

Мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээ, малын үржүүлэг, биотехнологийн лаборатори бүхий мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний үндсэн бааз, суурьтай болж, үйлчилгээний нэгжүүд бэхжин, мэргэжлийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

- Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдийн 60-аас доошгүй хувь нь үйлчилгээний стандартын 1 дүгээр зэрэглэлийн түвшинг хангасан байна.
- Малын архаг халдварт бруцеллёз, адууны халдварт цус багасах, ям, үхрийн лейкоз, сүрьеэ өвчнөөс бүрэн эрүүлжинэ.
- Мал сүргийн дунд зонхилон тохиолдох халдварт, паразиттах өвчний өвчлөл 5.0-10.0 хувиар, эдгээр өвчнөөр хорогдсон малын тоог 40.0-50.0 хувиар тус тус бууруулна.
- Нийт хээлтүүлэгчийг 100.0 хувь, үржлийн малын 60 хүртэлхи хувийг үржлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

- Сүү, махны үхэр, мах-ноосны хонь, сүүний ямааны 50.0 гаруй хувийг зохиомлоор хээлтүүлэх технологийн нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн 2 дугаар үе шатанд /2013-2021 он/:

Мал эмнэлэг, үржлийн ажлын чанар, хүртээмжийг сайжруулахад төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн үйлчилгээний нэгж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн идэвхитэй хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоо бүрдэж, мал сүргийг тогтвортой өсгөн, биологийн чадавхийг нь бүрэн ашиглах болно.

- Малын халдварт өвчнийг орон нутагтаа оношлох бүрэн боломжтой болж, мал амьтдаас хүнд халдварладаг өвчний тархалт буурч, хүн амын эрүүл мэндэд таатайгаар нөлөөлнө.
- Малын өвчлөл, ялангуяа халдварт, паразиттах өвчний түвшин, тэдгээрээс үүдэн гарах хохирлын хэмжээ буурна.
- Халдварт, паразиттах өвчний арга хэмжээнд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.
- Малын үржлийн бүртгэл, мэдээллийн сүлжээнд иж бүрэн хамрагдаж, бод малыг 100.0 хувь, бог малын 50.0 хувийг ээмэгжүүлнэ.

Найм. Хөдөө аж ахуйн салбарын чадавхи, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

8.1. Бэлчээрийн менежментийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

8.1.1. Дархан-Уул аймгийн бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал. Дархан-Уул аймаг нь Монгол орны байгалийн бүслүүрээр ойт хээрийн бүсэд багтдаг. Судлаачдын олон жилийн туршид бэлчээрийн ургацын олон жилийн дунджийг тогтоосноор манай бүс нутагт бэлчээрийн ургац зун-намар 5.3 цн/га, өвөл-хавар 3.1 цн/га байна.

Газрын нэгдмэл сангийн 2007 оны тайлангаар Дархан-Уул аймгийн бэлчээрийн талбай 188473.9 га, хадлан 9072.5 га байна.

1996 онд хонин толгойгоор 100 га бэлчээрт 181 толгой мал байсан бол 2004 онд 226 толгой, 2007 онд 174 толгой болж, энэ нь төвийн бүсийн дунджаас 7.5 дахин, улсын дунджаас 5.9 дахин илүү байна.

Нэг хонин толгойд 0.57 га бэлчээр оногдож байгаагаас үзэхэд бэлчээрийн өвс, ургамлын хэнзлэлтийг оруулан тооцоход л бэлчээрийн даац 2.9 дахин хэтэрсэн байна.

Тухайн жилийн бэлчээрийн ургацын байдал, малын тоо толгойноос хамааран бэлчээрийн хангамжийн байдлыг жил бүр тооцон үзэхэд аймгийн хэмжээгээр дунджаар 35.0-52.0 хувьтай байна.

Хэдийгээр 4 сумын малын тоо толгой бараг ижил хэмжээтэй боловч аймгийн бэлчээрийн даацыг бараг бүхэлд нь Хонгор, Орхон сум үүрч байна. Шарын гол, Дархан сумдын хувьд одоо байгаа малын тоонд бэлчээрийн хангамж дөнгөж 3.0-10.0 хувийг хангаж байгаа тул аймаг дотроо зохицуулалт хийж бэлчээрийн даацыг тэнцвэржүүлэх шаардлагатай байдаг.

Бэлчээрийн даацын хүрэлцээгүйгээс жил бүрт дунджаар 140 гаруй өрхийн 40.0 гаруй мянган толгой малыг Сэлэнгэ аймгийн Хушаат, Сайхан, Баянгол, Зүүнбүрэн, Жавхлант сумдын нутагт өвөлжүүлж байна.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт мал, малчин өрхийн тооны өсөлт, хэт төвлөрөл, бэлчээрийн ашиглалт, хөдөлгөөнт байдлын өөрчлөлт, улирлын бэлчээрийн хэт ачаалал, бэлчээрийн газрын зориулалт ба ашиглалтыг өөрчлөх, бэлчээрийн усан хангамжийн байдал, усны эх үүсвэрийн дутагдал, ургац хураалт ба улирлын бэлчээр ашиглалтын зөрчил зэрэг хүчин зүйлүүдийн улмаас жил бүр 2.5 га цөлжилтийн хүчтэй элэгдэлд орж, 14.0-15.0 мянган га бэлчээр талхлагдаж, бэлчээрийн хомсдолд орж байна.

Бэлчээрийн хомсдол хамгийн их байгаа Дархан суманд малтай өрхийн 73.3 хувь, нийт малын 49.3 хувь нь хот орчимд, тухайлбал, Дархан хотын нутаг дэвсгэрт байна. Сумын хэмжээгээр нэг хонин толгойд 0.02 га бэлчээр ноогдож байгаа нь уг суманд хот орчмын цөөн тооны мал бүхий эрчимжсэн суурин хэлбэрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зайлшгүй шаардаж байгаа юм.

Одоогийн малын хэт төвлөрөл, цаг уурын байдал, цаашдын төлөв байдал нь бэлчээрийг улам доройтуулан, цөлжилтөд оруулах аюул нүүрлэж байгаа тул бэлчээрийн менежментийн зөв бодлогыг хэрэгжүүлэх, бэлчээрийн даацдаа тохирсон мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх бодлогоо тодорхойлох нь тус аймгийн хувьд хойшлуулшгүй чухал асуудал болж байна.

8.1.2. Бэлчээрийн менежментийн зорилго. Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамжийг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг хийж, даацыг зөв тодорхойлсоны үндсэн дээр бэлчээрийн мэдлэгт суурилсан менежментийг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги :

- Сум бүрт “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө”-г боловсруулан, ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэн ажиллана.
- Бэлчээр, хадлангийн талбайг эзэмших, ашиглах эрхийг бүртгэлжүүлж, бэлчээр ашиглаж ирсэн бүс нутгийн онцлог, цаашдын шаардлагыг харгалзан малчдын бүлэг, хоршоонд 15-60 жилээр ашиглуулах болзол, нөхцөлтэй гэрээг байгуулна.
- Бэлчээрийн талаар гарсан хууль, тогтоомж, эрх зүйн холбогдолтой баримт бичгийг малчид, иргэдэд сурталчилна.
- Бэлчээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, бэлчээрийн мал аж ахуйн технологийн мэдлэг эзэмшүүлэх чиглэлээр сум, багийн хариуцах мэргэжилтнүүд, удирдах ажилтнууд, малчид, мал бүхий иргэдийг оролцуулсан сургалт, семинарыг зохион байгуулна.
- Малчдад нутаг, бэлчээрийн эзэмшил, ашиглалт, 4 улирлын бэлчээр, тэдгээрийн ургац, бүтээмж, отор, нүүдэл хийх хугацаа, тоо, цаг агаарын байдал, худаг, усны нөөц гэх мэт зүйлийг багтаасан мэдээллийн сан бий болгож, баяжилт хийнэ.

Тэргүүлэх зорилт 2. Бэлчээрийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх ажлыг төрийн болон мэргэжлийн байгууллага, олон улсын төслийн байгууллагууд, малчид, иргэдийн хамтын хүчээр зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Даац хэтэрсэн газарт илүү төлбөр тогтоох замаар бэлчээрийн даацыг зохицуулах ажлын эрх зүйн орчинг бий болгоно.
- Бэлчээрийн хуваарийг баримтлахын зэрэгцээгээр талхлагдсан бэлчээрийг тодорхой хугацаагаар малын хөлөөс чөлөөлөх, өвөл, хаврын бэлчээрийг сэлгэн ашиглах арга хэмжээг дэс дараалалтай авч хэрэгжүүлнэ.
- Малчдын нийгмийн болон бэлчээрийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэснээр алслагдсан зэлүүд бэлчээрийг ашиглах санаачилгыг дэмжинэ. /Хонгор сумын Зэдэрийн булаг, Могойн гол, Гахайт, Хар модот уул зэрэг газруудыг ашиглан, эзэмших/
- Мэргэжлийн болон эрдэм шинжилгээний холбогдох байгууллагатай хамтран ажиллах замаар бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлын үр дүнг дээшлүүлнэ.
- Аймгийн нутагт бага ургацтай, жижиг үетэн-агьт бэлчээрт үндсэн сайжруулалт хийснээр ургацыг 2-4 дахин нэмэгдүүлэх, мөн бэлчээрийг сэргээж, тэжээлийн ургамал тариалах, харьцангуй чийглэг буюу усалгаатай болгох боломжтой нутагт үетэн, буурцагтны үрийг шууд тариалах боломжийг судлан хэрэгжүүлнэ.
- Атаршсан газрыг эзэмших, орон нутагт тохиромжтой олон наст үет ургамлыг зурваслан тариалах замаар байгалийн үрийн нөөц үүсгэн атаржсан тариалангийн талбайг сэргээн, бэлчээрт шилжүүлэх арга замыг судлан, хэрэгжүүлнэ.

Тэргүүлэх зорилт 3. Алслагдсан бэлчээрийг усжуулах замаар бэлчээрийн даацын тэнцвэрт байдлыг хангана.

Хэрэгжүүлэх стратеги:

- Малчид, иргэдийн бэлчээртээ худаг гарган ашиглах үүсгэл, санаачилгыг дэмжинэ.
- Бэлчээр усжуулах ажилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах оновчтой арга, механизмыг нэвтрүүлнэ.
- Аймгийн бэлчээр усжуулалтын төлөвлөлтийг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргах худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.
- Бэлчээрийн даац сайтай нутгуудад уст цэгийн хайгуул хийлгүүлж, усжуулах чиглэлийг нэн тэргүүнд баримтална.
- Худаг, уст цэгийг малчдын бүлэгт удаан хугацаагаар эзэмшүүлэх замаар ашиглалтыг сайжруулна.
- Улсын төсвийн болон гадаадын байгууллагын хөрөнгө оруулалтаар шинээр гаргасан болон сэргээн засварласан худаг, уст цэгийн эзэмшил, ашиглалтын байдалд байнгын хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ.

8.1.3. Хүрэх үр дүн

- Бэлчээртэй холбоотой гарсан аливаа маргааныг бэлчээр ашиглалтын хуваарь, төлөвлөгөөг баримтлан шийдвэрлэх чадвар, эрх зүйн орчин дээшилнэ.
- Бэлчээрийг даацад нь тохируулан улирлын хуваарьтай, тогтвортой ашиглах, хамгаалах явдал хэвшиж, улирлын болон нөөц бэлчээрийн хангамж сайжирна.
- Нийт бэлчээрийн 10 хүртэлхи хувийг хашин хамгаалж, үндсэн сайжруулалт хийж, бэлчээрийн доройтлын түвшин буурсан байна.

- Бэлчээрийн зориулалттай худаг, уст цэгийн тоог 1 дахин нэмэгдэж, нийт бэлчээрийн 80.0 хувийг усжуулсан байна.

8.2. Малын тэжээлийн хангамжийн өнөөгийн байдал, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн

8.2.1. Өнөөгийн байдал. Дархан-Уул аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх бодит нөхцөл байдалтай уялдуулан тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна.

Нийт малд шаардлагатай тэжээлийн хэрэгцээг жил бүр тооцсоны үндсэн дээр мал бүхий баг, аж ахуйн нэгж, иргэдэд хадлан, тэжээл бэлтгэлийн даалгаврыг өгсөнөөр 18.0-20.7 мянган тонн тэжээлийн нэгж, үүний дотор 40.0-50.0 гаруй мянган тонн байгалийн хадлан, 0.8-1.5 мянган тонн хочит тэжээл, 0.5-2.0 мянган тонн ногоон тэжээл бэлтгэж тэжээлийн нөөцийг бий болгож байна.

Ингэснээр нийт малын 54.0-76.0 хувийг байран ба нэмэгдэл тэжээлд оруулах нөхцлийг бүрдүүлж, нэг хонин толгойд 45.2-48.2 кг тэжээл ноогдож байна.

Нэг хонин толгойд ноогдож буй тэжээлийн хэмжээгээр бүсийн дунджаас 4.0, улсын дунджаас 5.5 дахин илүү байна.

Аймгийн мал аж ахуйг эрчимжүүлэн, суурин, хагас суурин мал аж ахуй эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх, бэлчээрийн даацын хэтрэлт, бэлчээрийн доройтлыг багасгах зорилтын хүрээнд хийх чухал ажил бол малын тэжээлийн бааз, суурийг өргөтгөх явдал юм.

Ган, зудын давтамж ойртож байгааг бодолцож, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, таримал болон удаан хадгалагдах овор багатай шимт чанар сайтай тэжээл бэлтгэх ажилд анхаарал тавих хэрэгтэй байна.

8.2.2. Малын тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги

Тэргүүлэх зорилт 1. Малын тэжээл бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэн, тэжээллэгийн технологийг мөрдүүлэх, тэжээлд хамруулах малын тоог өсгөх замаар хагас суурин ба суурин хэв шинжийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн үндсэн нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Тэжээлийн бүтцэд чанарын өөрчлөлт гаргаж, хүчит болон биологийн гаралтай тэжээлийг нэмэгдүүлэх технологийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Иргэд, аж ахуйн нэгжээс гарч буй хашаажсан болон таримал бэлчээр бий болгох, тэжээлийн ургамал тариалах, бэлчээрийг нөхөн сэргээх бүхий л санаачилгыг дэмжинэ.
- Тэжээлийн ургамлын үр импортоор оруулж ирэх, үр үйлдвэрлэх талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.
- Усалгаатай тариаланг түшиглэн тэжээлийн ургамал тариалах явдлыг дэмжинэ.
- Тариалангийн сэлгээнд таримал тэжээлийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

Тэргүүлэх зорилт 2. Малын тэжээлийн бүтцэд чанарын өөрчлөлт гарган, хүчит болон биологийн гаралтай тэжээлийг нэмэгдүүлэх зорилгоор тэжээлийн үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран тэжээл бэлтгэх шинэ техник, технологийг судлан нэвтрүүлнэ.
- Тэжээлийн үйлдвэр байгуулан ажиллуулах санаачилгыг дэмжин, малын болон гахай, шувууны олон найрлагат тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Тэргүүлэх зорилт 3. Малын тэжээлийн баазыг өргөтгөн, сум бүрт аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн фондыг бий болгож, мал аж ахуйн гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Аймгийн хадлангийн нөөц газрыг тогтоон, хамгаалалтад авч, сайжруулалт хийх ажилд хөрөнгө оруулалт хийнэ.
- Мал бүхий сум, баг, малчин бүр нийт малыг 5-аас доошгүй хоног тэжээх тэжээлийн нөөц бий болгох бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

8.2.3. Хүрэх үр дүн

- Тэжээл бэлтгэлийн хэмжээг 40.0 хүртэл хувиар нэмэгдүүлэн, нэг хонин толгойд 60 кг-аас доошгүй тэжээл бэлтгэсэн байна.
- 1100 га-д тэжээлийн ургамал тариалан, таримал тэжээлийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлнэ.
- Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны олон найрлагат тэжээлийн хангамж сайжирсан байна.

8.3. Хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөц, сургалт, нэвтрүүлэлтийн үйлчилгээний өнөөгийн байдал, тэргүүлэх зорилтууд, хүрэх үр дүн

8.3.1. Өнөөгийн байдал

2005 онд аймагт Хүнс, хөдөө аж ахуйн газрыг байгуулан уг байгууллагыг бэхжүүлэхэд анхаарч ажилласнаар одоо 3 алба, ХАА-н Нэвтрүүлэлтийн үйлчилгээ, Хөдөө аж ахуйн сургалтын төв, мал эмнэлэг, ариун цэврийн иж бүрэн лаборатори бүхий байгууллага болж өргөжин, 20 гаруй хүмүүс ажиллаж байна.

1998 онд Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг Нэвтрүүлэх төвийг аймагт байгуулан, одоогоор 4 сум, 2 багийн түвшинд Нэвтрүүлэлт төвүүдийг ажиллуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг техник, технологийн мэдлэг, мэдээллээр хангах зорилгоор сургалтуудыг зохион байгуулж байна.

Нэвтрүүлэлтийн үйлчилгээг орон нутагт явуулж эхэлсэн 10 жилийн хугацаанд нийт 119 сургалт, талбайн өдөрлөг, үзүүлэх сургуулийг зохион байгуулан, 4714 хүнийг хамруулсаны зэрэгцээгээр бизнес зөвөлгөө өгөх, төсөл боловсруулах аргачлал өгөх, зөвлөмжүүдийг боловсруулан үйлдвэрлэгчдэд түгээх зэрэг ажлыг орон тооны бус зөвлөхүүдийг түшиглэн, тогтмол зохион байгуулж байна.

Нэвтрүүлэлтийн үйлчилгээг зохион байгуулах бааз, суурийг бэхжүүлэх зорилгоор аймагт 1, бүх сумдад тус бүр нэг Агропаркыг байгуулан, хүлэмж, зоорийн аж ахуйн хамт өргөжүүлэн хөгжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийн сургалтуудыг зохион байгуулж байна.

Түүнчилэн тус аймагт Монгол улсын газар тариалангийн шинжлэх ухааны толгой байгууллага болох Ургамал, газар тариалан, сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн үйл ажиллагаагаа явуулж судалгаа, шинжилгээний ажлын зэрэгцээгээр ХААИС-ийн салбар сургуульд хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг сургаж байна.

8.3.2. Хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөц, нэвтрүүлэлтийн үйлчилгээ, сургалтын тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги

Тэргүүлэх зорилт 1. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэн, аймаг, сумдын ХАА-н Нэвтрүүлэх төвүүдийг бэхжүүлэх, төсөл хөтөлбөрүүдтэй өргөн хүрээнд хамтран ажиллах замаар Нэвтрүүлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд үйлдвэрлэлээ үр ашигтай эрхлэх арга ухаанд сургах, шинжлэх ухааны ололт, шинэлэг техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, сурталчилах, мэдлэг түгээх арга хэлбэрийг боловсронгуй болгоход анхаарч, шаталсан сургалтуудыг зохион байгуулна.
- ХАА-н Нэвтрүүлэх төвүүдийн боловсон хүчнийг гадаад, дотоодын сургалтад хамруулах замаар чадавхийг нь бэхжүүлнэ.
- Нэвтрүүлэлт төвүүдийн орон тооны бус зөвлөхүүдтэй гэрээний үндсэн дээр зохистой хэлбэрээр хамтран ажиллаж, эдийн засгийн урамшуулалтай болгосноор нэвтрүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- Богино хугацааны албан бус сургалтаар олгох мэдлэг, мэдээллийн ач холбогдлыг харгалзан, сургалт зохиоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулан ажиллана.
- ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх үйлчилгээний цар хүрээ, чанар, хүртээмжийг дээшлүүлэхийн тулд салбарын чиглэлээр орон нутагт ажиллаж буй Төрийн бус байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтран ажиллана.

Тэргүүлэх зорилт 2. Эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллагсадын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажиллана.

Хэрэгжүүлэх стратеги:

- Эрдэм шинжилгээний байгууллагад судалгаа, шинжилгээний захиалгыг өгч, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд хамтран ажиллана.
- Хөдөө аж ахуйн их сургуульд хөдөө аж ахуйн мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургалтыг шинээр бий болгон фермерийн ажилтан, механикжуулагчид, ногоочид, зоорь, хүлэмжийн аж ахуйн ажилтан, гахайчид, шувуучид, зөгийчдыг сурган, бэлтгэх ажлыг зохион байгуулна.
- Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг мэргэжлийн зэрэг олгох сургалтад үе шаттайгаар хамруулах ажлыг зохион байгуулна.

8.3.3. Хүрэх үр дүн:

- Хөдөө аж ахуйн Нэвтрүүлэлтийн хүрээ өргөжин, сум, багийн түвшинд үйлчилгээ үзүүлдэг чадавхитай болно.
- Хөдөө аж ахуйн салбарт мэргэжилтэй ажиллагсадын тоо нэмэгдэж, үйлдвэрлэлийг үр ашигтай эрхлэн явуулах нөхцлөөр хангагдана.

ХАВСРАЛТ ЗУРАГ, ТООЦОО, СУДАЛГААНУУД

Дархан-Уул аймгийн “Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”-ыг боловсруулах явцад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн одоогийн байдлын түвшинг тогтоохоор хийсэн судалгаа болон 2008-2021 он хүртэлхи салбарын үйлдвэрлэлт, хүн амын хүнсний хэрэгцээг хангахтай холбоотой төлөвлөлт, тооцоонуудыг доорхи хавсралтад дурдсанаар хийсэн болно.

[**Зураг 1. Газар тариалангийн дэд салбаруудаар бүсчилэн хөгжүүлэх зураглал**](#)

[**Зураг 2. Мал аж ахуйн дэд салбаруудаар бүсчилэн хөгжүүлэх зураглал**](#)

[**Зураг 3. Тэжээлийн үйлдвэрлэлийг бүсчилэн хөгжүүлэх зураглал**](#)

[**Хавсралт 1. Аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийн судалгаа /1990, 1995, 2000-2007 оноор/**](#)

[**Хавсралт 2. Аймгийн Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын судалгаа /2007 оны байдлаар/**](#)

[**Хавсралт 3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн хэтийн төлөвлөлт /2008-2021 оноор/**](#)

[**Хавсралт 4. Хүнсний ногооны үйлдвэрлэлтийн хэтийн төлөвлөлт /2008-2021 оноор, таримлын төрөл бүрээр/**](#)

[**Хавсралт 5. Тариалалтад шаардагдах үрийн хэрэгцээний төлөвлөлт /2008-2021 оноор/**](#)

[**Хавсралт 6. Аймгийн малыг өсгөх сүргийн эргэлтийн тооцоо /2008-2021 оноор, малын төрөл тус бүрээр/**](#)

[**Хавсралт 7. Шувууг өсгөх сүргийн эргэлтийн тооцоо /2008-2021 оноор/**](#)

[**Хавсралт 8. Аймгийн гахайг өсгөх сүргийн эргэлт /2008-2021 оноор/**](#)

[**Хавсралт 9. Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэтийн төлөвлөлт /2008-2021 оноор, бүтээгдхүүн тус бүрээр/**](#)

[**Хавсралт 10. Аймгийн хүн амын хүнсний бүтээгдхүүний хэрэгцээ, дотоодын үйлдвэрлэлээр хангах тооцоо /2007-2020 оноор/**](#)

[**Хавсралт 11. Зоорь ба хүлэмжийн аж ахуйн төлөвлөлт /2008-2021 оноор/**](#)

[**Хавсралт 12. Мал эмнэлэг, үржлийн мэргэжлийн ажил, үйлчилгээний төлөвлөлт /2007-2021 оноор/**](#)

[**Хавсралт 13. Цэвэр, эрлийз болон нутгийн шилмэл омгийн малыг өсгөх сүргийн эргэлтийн тооцоо /2008-2021 оноор/**](#)

[**Хавсралт 14. Селекцийн дүнд бий болгох мал аж ахуйн бүтээгдхүүний нэмүү үйлдвэрлэлийн тооцоо /2008-2021 оноор/**](#)

Хавсралт 15. Малын тэжээлийн үйлдвэрлэлтийн хэтийн төлөвлөлт /2008-2021 оноор/

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс
Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар**